



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар A/211


Мандалговь

Хөрөнгө төвлөрүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а" дахь заалт, "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалт, Аймгийн онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Коронавируст (Ковид-19) цар тахлын тархалт аймгийн нутаг дэвсгэрт хурдацтай тархаж байгаатай холбогдуулан урьдчилан сэргийлэх, тандалт шинжилгээ хийх, ковидын эмнэлэг, тусгаарлах байрыг нэмэгдүүлэн ард иргэдийг аюулт цар тахлаас урьдчилан сэргийлэх, эмчлэх үйл ажиллагааны зардалд улс, орон нутгийн төсвийн байгууллагууд батлагдсан төсвийнхөө 1 хувь хүртэлх зардлыг Аймгийн онцгой комиссын дансанд төвлөрүүлэхийг бүх шатны төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван)-д үүрэг болгосугай.



481210911